



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 4/24

Арвайхээр

Эд хөрөнгийн тооллогын комисс  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Монгол Улсын төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйл, Монгол улсын Засгийн газрын "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай" 09 дүгээр тогтоол, Татварын хэлтсийн "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 11 дүгээр зүйл, Татварын хэлтсийн даргын 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/30 дугаартай Өмч хамгаалах зөвлөлийн шинэчлэн байгуулах тушаал зэргийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэг тооллого, Хэлтсийн 2022 оны эхний хагас жилийн өмч хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, бүртгэлжүүлэлтийн байдлыг тогтоох, эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: П.Байгальмаа (Татварын хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагч)

Гишүүд: С.Оюун-Эрдэнэ (Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагч)

Б.Бямбасүрэн (Хуулийн асуудал хариуцсан, хураагч)

Д.Отгонтуяа (Архив бичиг, хэргийн эрхлэгч)

Х.Түвшин (Сүлжээний инженер, нярав)

2. Тооллогыг 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийг дуустал зохион байгуулж, тооллогын дүнг нэгтгэн цаашид ашиглах боломжгүй, засварлах шаардлагатай хөрөнгийн жагсаалтыг гаргаж, Өмч хамгаалах зөвлөлийн хуралд танилцуулахыг комиссын дарга (Л.Буянжаргал), тооллогын комиссын дарга (П.Байгальмаа)-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/39 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЭРДЭНЭСУВД



621001047